



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2023/101/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Алтай хот
2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр

Утас: 70483413 Цахим хаяг:
tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055 Цахим хаяг:
erdenechimegd@audit.gov.mn

“Анализ старт аудит” ХХК-ийн
Ахлах аудитор А.Батжаргал
Утас: 99291595
Цахим хаяг: asaudit.mn@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган. төгрөг/

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	55,241.4	154,299.1
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	270,744.5	274,527.2
	Нийт хөрөнгийн дүн	325,985.8	416,272.3
	Нийт өр төлбөрийн дүн	0.0	0.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	325,985.8	428,826.3
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	325,985.8	428,826.3
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	559,600.4	597,183.3
	Үйл ажиллагааны зардлын дүн	504,695.1	491,741.4
	Үйл ажиллагааны үр дүн	54,905.3	105,441.9
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	2,601.3
	Үйл ажиллагааны нийт үр дүн	54,905.3	102,840.5
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	271,080.6	340,544.8
	Тайлант оны үр дүн	54,905.2	102,840.5
	Эцсийн үлдэгдэл	325,985.8	428,826.3
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	452,407.6	437,114.9
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	444,334.6	432,074.9
	Үйл ажиллагааны ЦМГ	8,073.0	5,040.0
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	8,073.0	5,040.0
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		0.0
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	429,492.6	403,485.0
	Урсгал зардал	429,492.6	403,485.0
	Хөрөнгийн зардал	0.0	0.0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	429,492.6	403,485.0
	Улсын төсвөөс санхүүжих	429,492.6	403,485.0
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	0.0	0.0
	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	0.0	0.0
Нэмэлт санхүүжилтийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		7,622.3
	Урсгал зардал		7,622.3
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		7,622.3
	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		7,500.0
	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		122.3
	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл		

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 12.6 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитаар залруулсан. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой: Байгууллагын бүртгэсэн нэгж талбарын хэмжээ бодит газрын хэмжээнээс зөрүүтэйгээс 627.7 м.кв 1 нэгж газрыг дутуу бүртгэн 12.6 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн зөрүүтэй илэрхийлсэн алдаа гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 8.9 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 1.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 7.9 сая төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх 8 заалт албан шаардлага, хуулийн хэрэгжилт хангах 1 заалт зөвлөмж хүргүүлсэн.

3.1 Төлбөрийн акт

- ✓ Ажилтанд 0.02 сая төгрөгийн листийн мөнгийг олгоогүй нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 17-р зүйлийн 17.1-т "1.Ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдахаас өмнө 3, түүнээс дээш сарын хугацаагаар тэтгэмжийн даатгалын шимтгэл төлж ажилласан даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрхтэй." гэсэн заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Ажилтанд ажил хавсарсны нэмэгдлийг 0.3 сая төгрөгөөр илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2-т "Энэ хуулийн 56.1-д заасны дагуу ажиллах ажилтанд гүйцэтгэх ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг нэмж олгоно" гэсэн заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Үр дүнгийн урамшууллыг 0.5 сая төгрөгөөр илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.11-т "Сургалтын байгууллагын эрхлэгч, захиралд улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг томилсон эрх бүхий албан тушаалтан гаргана." гэсэн заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Амралтын цалинг 0.03 сая төгрөгөөр давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." гэсэн заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- ✓ ТҮ-1-р ангиллаар цалинждаг үйлчлэгч ажилтай ажилтанд 0.01 сая төгрөгийн орон нутгийн болон хортой нөхцөлд ажилласны нэмэгдэл олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтын 2-т "Орон нутагт ажилласны нэмэгдлийг дараах албан тушаал эрхэлж байгаа эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож сар бүр олгоно", 7 дугаар хавсралтын 1-т "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа төрийн үйлчилгээний албан хаагчид хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна" гэсэн заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Албан шаардлага

- ✓ Даргын тушаал шийдвэргүй 0.6 сая төгрөгийн эм боох материалыг акталсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 20 дугаар зүйлийн 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэн заалтыг зөрчсөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Ажилтанд төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 0.3 сая төгрөгийг олгосон боловч Захирлын 2022 оны Б/10 дугаар тушаалын хавсралтад зааж өгөөгүй нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 5-т "Төрийн алба хаасан хугацааг байгууллагын хүний нөөцийн асуудал эрхэлсэн нэгж буюу ажилтан тодорхойлж, тухайн байгууллагын төсвийн шууд захирагчийн тушаалаар энэ журмын 2-т заасны дагуу нэмэгдэл олгох хувийг тогтооно" гэсэн заалтыг зөрчсөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаасны зардлыг хэмнээгүй 0.3 сая төгрөгийн бичгийн цаасыг өмнөх оноос илүү зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4-т "бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх" гэсэн заалтыг зөрчсөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Бичиг хэргийн батлагдсан төсвийг 2.5 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4-т "бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт



шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх" гэсэн заалтыг зөрчсөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- ✓ Нийгмийн даатгалын тайланд групптэй ажилтны цалинг тайлагнахдаа ангилал буруу бүртгэж (01)-ээр тайлагнаж 0.2 сая төгрөгийн илүү шимтгэл төлсөн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх", Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 246, А/245 дугаар хамтарсан тушаалын 2 дугаар хавсралт заалтыг зөрчсөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Аж ахуйн нэгж, байгууллагаас 1.6 сая төгрөгийн и-баримтгүй худалдан авалт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн заалтыг зөрчсөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Өмнөх аудитаар Татварын тодорхойлолтоор 2.2 сая төгрөгийн зөрүү тооцоо татварын цахим системд бүртгэлтэй нь Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4-т "төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг бүрэн ирүүлэх"; 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах"; Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана", гэсэн заалтыг зөрчсөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Томилолтын хуудсанд ирсэн явсан огноогүй байхад 0.2 сая төгрөгийн томилолт олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн 2.1-т "Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой

хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно" гэсэн заалтыг зөрчсөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ", заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авто тээврийн хэрэгсэлд тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэх Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Говь-Алтай аймгийн Зоонозын өвчин судлалын төв	1	12.5			1	12.5			-	-	-	-
Дүн	1	12.5			1	12.5			-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Говь-Алтай аймгийн Зоонозын өвчин судлалын төв	11	5.0	5	0.9	6	4.1	-	-	-	-	-	-



Дүн	11	5.0	5	0.9	6	4.1	-	-	-	-
-----	----	-----	---	-----	---	-----	---	---	---	---

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/					
			Үүнээс					
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Говь-Алтай аймгийн Зоонозын өвчин судлалын төв	3	3.9	-	-	2	3.9	1	
Нийт дүн	3	3.9	-	-	2	3.9	1	

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	1		-	-
	НИЙТ	1	1	-	-	1		-	-